



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 329

Улаанбаатар хот

“Глобаль траст секьюритис” ХХК-ийн  
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 30.1.2, 63.1.5 дахь заалт болон Хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 11.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Глобаль траст секьюритис” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. “Глобаль траст секьюритис” ХХК-ийн тусгай зөвшөөрөл хүчингүй болсонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Хорооны архивт шилжүүлэхийг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/-т үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийт, харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН